



Хил Хязгааргүй  
Сурвалжлагчид



**RSF-ИЙН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС**

**ЗАСГИЙН ГАЗАР ХОНКОНГИЙН  
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ХАЛДСАНААС  
ХОЙШИХ ХОЁР ЖИЛ**





## Засгийн газар Хонконгийн хэвлэл мэдээлэлд халдсанаас хойших хоёр жил


Хонконг БНХАУ-ын мэдэлд шилжсэнээс хойш нэгэн зууны дөрөвний нэг нь өнгөрсөн боловч тус бүс нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй Суурь хуулиар 2047 он хүртэл баталгаажуулсан хэвлэлийн эрх чөлөөний зарчим урьд өмнө байгаагүй ихээр аюул заналхийлэлтэй тулгараад байна.

Бээжин нэгэн зууны хугацаанд Хонконгийн хятад хэл дээрх хэсэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг хяналтдаа авч, зар сурталчилгаа нийлүүлэгчдээрээ дамжуулан бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шууд бусаар дарамт шахалт учруулав.

2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Хятадын хууль тогтоох дээд байгууллага болох Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооноос “Хонконгийн засаг захиргааны онцгой бүсэд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай БНХАУ-ын хууль” буюу Үндэсний аюулгүй байдлын хэмээн нэршсэн хууль батлагдсанаар байдал улам дордсон юм.

Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) олон улсын байгууллага тус бүс нутгийн орчин үеийн түүхэнд хэвлэлийн эрх чөлөө хамгийн ихээр доройтсонд тооцогдож буй энэхүү хоёр жилийн хугацааг нарийвчлан судлаж байна.

Анх удаа хорь гаруй сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч саатуулагдан баривчлагдаж, өдгөө тэдний 12 нь шүүх хурлаа хүлээн хоригдож буй бөгөөд хараат бус хоёр хэвлэл мэдээллийн хэрэгслийг засгийн газраас үйл ажиллагааг нь хүчээр зогсоов. Үүний зэрэгцээ, Хонконгийн захирагч Кэрри Лам Бээжингийн эрх баригчдын таалалд нийцэхийн тулд хэвлэлийн эрх чөлөөний бэлгэ тэмдэг болсон RTHK олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага (Хонконгийн радио, телевиз)-ыг онилох болов.



## Дөрөвдүгээр сар

### 15-ны өдөр

Хонконг дахь Хятадын харилцаа холбооны газрын дарга Луо Хуйнин тус нутаг дэвсгэрт өрнөж буй ардчиллын төлөөх хөдөлгөөнийг зогсооход чиглэсэн Үндэсний аюулгүй байдлын хуулийн төслийг яаралтай батлан гаргахыг уриалав. Хонконгийн захирагч 2002 онд ийм хууль батлахыг анх санаачилж байсан боловч хагас сая хонконгчууд гудамжинд жагсаж эсэргүүцлээ илэрхийлсний улмаас жилийн дараа тус хуулийг тэр даруй эгүүлэн татсан.

## Тавдугаар сар

### 19-ний өдөр

Хонконгийн радио, телевиз (РТНК) 2020 оны хоёрдугаар сарын дугаартаа Хонконгийн цагдаа нарыг элзлэснээс улбаалан албан ёсны гомдол хүлээн авсныхаа дараа цаг үе, үйл явдлын "Хөтлөгч" хэмээх алдартай, хошин шоу нэвтрүүлгээ зогсоов.

### 21-ний өдөр

Хонконгийн радио, телевизийн Зөвлөхүүдийн зөвлөл олон нийтийн өргөн нэвтрүүлгийн засаглал, редакцийн зарчимд хяналт тавих чиг үүрэг бүхий "ажлын хэсэг" байгуулснаа зарласан бөгөөд уг ажлын хэсэгт удирдлага, ажилтнуудын төлөөллийн хэнийг ч үл оруулав.

### 28-ны өдөр

Хятадын парламент буюу Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаас "төрийн эсрэг" бүрхэг тодорхойлт бүхий дөрвөн төрлийн гэмт хэрэг үйлдсэний төлөө бүх насаар хорих ялтай Хонконгийн Үндэсний аюулгүй байдлын хууль батлан гаргав.

## Зургадугаар сар

### 10-ны өдөр

РТНК олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын Зөвлөхүүдийн зөвлөлийн дарга Евгений Чан тус сувгаас Үндэсний аюулгүй байдлын хуулийн талаар "зөв ойлголт"-ыг таниулан сурталчилсан цуврал нэвтрүүлэхийг олон нийтийн өмнө шаардав.

### 18-ны өдөр

Хонконгийн Сэтгүүлчдийн холбоо (НКЖА)-ны судалгаагаар дотоодын сэтгүүлчдийн 98 хувь нь Үндэсний аюулгүй байдлын хуулийг өөрсдийнх нь эсрэг чиглэнэ хэмээн эмээж буйг тогтоов.

### 24-ний өдөр

Хонконгийн Гадаадын сурвалжлагчдын клуб (ФСЧНК) Кэрри Лам захирагчид Үндэсний аюулгүй байдлын хуулийн хэвлэлийн эрх чөлөөнд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар тодруулга хүссэн нээлттэй захидал илгээв.

### 30-ны өдөр

Хятадын төрийн хууль тогтоох дээд байгууллага болох Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хороо Үндэсний аюулгүй байдлын хуулийг батлаж, улмаар уг хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэв.



# 國家安全法

## National Security Law

保一國兩制  
Preserve One Co



中華人民共和國香港特別行政區  
Hong Kong Special Administrative Region  
of the People's Republic of China

# Үндэсний аюулгүй байдлын хууль

© Хонконгийн засгийн газар. 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Хонконгийг Их Британиас шилжүүлсний 23 жилийн ойг тохиолдуулан Үндэсний аюулгүй байдлын шинэ хуулийг дэмжсэн агуулга бүхий самбарын дэргэд Хонконгийн төрөл бүрийн хүчний төлөөлөл зогсож буй нь.

2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Хятадын хууль тогтоох дээд байгууллага болох Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хороо “Хонконгийн засаг захиргааны онцгой бүсэд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай БНХАУ-ын хууль” батлав. Хонконгийн бие даасан байдал, 1984 оны Хятад, Их Британийн хамтарсан тунхагийг балмадаар үл тоомсорлон баталсан тус хууль Хятадын эрх баригчдад Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн хэрэгт хөндлөнгөөс шууд оролцох, бүх насаар хорих ялтай "төрийн эсрэг гэмт хэрэг" гэж үзсэн хэргийг шийтгэх боломж олгодог. Ийм бүрхэг зохицуулалт нь дур зоргоор баривчлах үүд хаалгыг нээж, ялангуяа сэтгүүлчид, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг сүрдүүлэн заналхийлж болзошгүй юм.

“Үндэсний аюулгүй байдалд заналхийлэх зорилгоор гадаадын хүчнүүдтэй буюу хөндлөнгийн этгээдүүдтэй үгсэн хуйвалдах”

### • Хонконг дахь хэрэгжилт

2020 онд, Apple Daily сониныг үүсгэн байгуулагч **Жимми Лай** энэ хэргээр ял шийтгүүлсэн. 2021 онд Apple Daily сонины сэтгүүлчдийг оролцуулан зургаан ажилтан "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдах"-д Лайтай үгсэн тохирсон хэргээр ял шийтгүүлсэн. 2020 оны нэгдүгээр сард Хонконгийн захирагч Кэрри Лам гадаадын хэвлэл мэдээлэл, тэр бүү хэл гадаадын оршин суугчдын үүсгэн байгуулсан Хонконгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг барууны засгийн газруудын гар хөл байх магадлалтай хэмээв.

“Хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах”

### • Хонконг дахь хэрэгжилт

Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч **Клаудиа Мо, Гвинет Хо Квай-лам** нар тус нутаг дэвсгэр дэх ардчилал, хэвлэлийн эрх чөлөөг дэмжсэний төлөө энэ хэргээр 2021 онд саатуулан баривчлагдсан. Тусгаар тогтнолыг дэмжсэн үйл явдлын талаар мэдээлсэн, тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийн хэлсэн үгийг эш татсан сэтгүүлчид, мөн Хятадын дэглэмийн талаар шүүмж буюу эрэн сурвалжлах нийтлэл бичсэн сэтгүүлчдийг тус гэмт хэрэгт холбогдуулж ялладаг.

## ■ “Салан тусгаарлах үйл ажиллагаа явуулах”

### • Хонконг дахь хэрэгжилт

Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу Хонконгийн соёлын онцлог мөн чанар, тусгаар тогтнолыг дэмжигч хөдөлгөөний талаар бичсэн ямар ч сэтгүүлчийг “салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан” хэргээр буруутган ялладаг. Financial Times сонины Азийн мэдээний редактор **Виктор Маллетийг** Гадаадын сурвалжлагчдын клуб (FCC)-ээс тусгаар тогтнолын төлөө тэмцэгчийг оролцуулан, зохион байгуулсан мэтгэлцээний чиглүүлэгчээр ажилласан хэргээр 2018 онд Хонконгоос албадан гаргасан. Тухайн үед Аюулгүй байдлын хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бол Маллетыг

## ■ “Террорист үйл ажиллагаа явуулах”

### • Хонконг дахь хэрэгжилт

Хятадын эрх баригчид болон Хонконгийн захирагчийн зүгээс ардчиллын төлөөх хөдөлгөөнийг ихэнхдээ "террорист үйл ажиллагаа" гэж үздэг тул жагсаал цуглаан болж буй газраас сурвалжлах нь Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу террорист үйл ажиллагаа явуулсан хэрэгт буруутгагдах эрсдэлтэй. Үүний адилаар Хятадад ийм төрлийн хөдөлгөөний талаар мэдээлсэн гадаадын сэтгүүлчдийг "терроризмийг дэмжсэн" хэргээр саатуулан баривчлах буюу албадан гаргах заалттай.

## Долдугаар сар

### 7-ны өдөр

Кэрри Лам захирагчийн хэлснээр, “Хонконг дахь бүх сэтгүүлч” Үндэсний аюулгүй байдлын хуульд заасан аюулгүй байдлын эсрэг хэрэг хийхгүй гэсэн “100 хувийн баталгаа” өгвөл хэвлэлийн эрх чөлөө баталгаажих болно.

### 14-ний өдөр

Үндэсний аюулгүй байдлын хууль батлагдсантай холбогдуулан New York Times сонины редакц Хонконг дахь ажилтнуудынхаа гуравны нэгийг Өмнөд Солонгос руу нүүлгэн шилжүүлэх гэж буйгаа мэдэгдэж, сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь "одоо урьд өмнөхөөсөө илүү чухал" болсон тул "тооцоолоогүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гаргаж, редакцийн ажилтнуудаа бүс нутгаар тархаан байршуулах" шаардлагатай байгаагаа илэрхийлэв.

### 29-ний өдөр

Хонконгийн цагдаагийн хүчнийхэн EggEggClub News, HKGolden, Ben Yu Entertainment Ltd, Community Media, PSHK зэрэг Хонконгийн дор хаяж таван цахим мэдээллийн хэрэгслийг Үндэсний аюулгүй байдлын газрын ахлах захирагч Стив Литэй хийсэн хэвлэлийн бага хурлыг орхин гарахыг шаардсан.

## Наймдугаар сар

### 6-ны өдөр

Гадаадын сурвалжлагчдын клуб (FCCNK)-ээс тус нутаг дэвсгэрт байгаа гадаадын сурвалжлагчид визний "жирийн бус" асуудалтай тулгарч буй тухай мэдэгдэж, сүүлийн хэдэн сарын хугацаанд олон хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс виз нь саатсан талаар мэдээлэв.

### 10-ны өдөр

Хонконгийн хятад хэл дээрх хамгийн том сөрөг хүчний Apple Daily сонины төв байранд хоёр зуун цагдаа дайран орж, үүсгэн байгуулагч Жимми Лайг "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан" хэрэгт сэжиглэн, 40 цагийн турш саатуулан баривчлав.





# Жимми Лай

© Peter Parks/ AFP

Apple Daily сониныг үндэслэгч, RSF-ийн 2020 оны Хэвлэлийн эрх чөлөөний шагналтан тэрбээр сүүлийн 30 жилийн турш Хонгконг дахь хэвлэлийн эрх чөлөө, ардчиллын төлөө тууштай тэмцэж буй. 2020 оны 12 дугаар сараас хойш шоронд хоригдож байгаа түүнийг хэд хэдэн гэмт хэрэгт буруутгаад байгаа бөгөөд үүний хоёр нь Үндэсний аюулгүй байдлын хуультай холбоотой. Жимми Лайд гурван удаа “зөвшөөрөлгүй” жагсаал цуглаан “зохион байгуулсан”, түүнд “оролцсон” хэргээр 20 сарын хорих ял хэдийнээ ногдуулаад байна. Өмнөх жилүүдэд тэрбээр үүсгэн байгуулсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамт эрх бүхий албан тушаалтнуудын байнгын дарамт шахалтад өртөж, мөн хэд хэдэн гэмт хэргийн халдлагын золиос болж байв.

## Наймдугаар сар

### 11-ний өдөр

Хонконгийн цагдаагийн хүчнийхэн наймдугаар сарын 10-нд Apple Daily сонины байранд дайран орох үеэр Reuters, AFP, AP, Stand News, InMedia зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулан хэд хэдэн дотоодын болоод олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл цуглуулах эрхийг хязгаарласны дараа “цагдаагийн үзэж буйгаар мэргэжлийн бус байдал” гаргаагүй, гагцхүү “итгэл хүлээсэн хэвлэл мэдээллийнхэн”-д газар дээрх ажиллагааг нь сурвалжлах эрх олгоно хэмээн мэдэгдэв.

### 13-ны өдөр

Хонконгийн радио, телевизийн зүгээс хууль тогтоох зөвлөлийн сонгуулийн талаар 7 дугаар сарын 31-нд идэвхтэн Натан Лоутай хийсэн ярилцлагыг эфирээс хассанаа мэдэгдэв. Хонконгийн цагдаагийн газраас түүнийг “Үндэсний аюулгүй байдлын хууль зөрчсөн хэрэгт сэжиглэгдэж” буйн улмаас эрэн сурвалжилж буй тухай батлагдаагүй мэдээлэл гарсан нь ийн нөлөөлжээ.

### 19-ний өдөр

Хонконгийн Сэтгүүлчдийн холбоо болон Хонконгийн радио, телевизийн хөтөлбөрийн ажилтнуудын холбооноос тус радио, телевизийн “Хөтлөгч” нэртэй шоу нэвтрүүлгийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний дугаарт цагдаа нарыг “доромжилсон” гэх үндэслэлээр анхааруулга өгсөн засгийн газрын харьяа Харилцаа холбооны газрыг тайлбар өгөхийг шаардав.

### 25-ны өдөр

Ирландын редактор **Аарон Мак Николас** 2015 оноос хойш Хонконгд ажиллаж байгаа бөгөөд түүнийг хараат бус цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох Хонконгийн чөлөөт хэвлэл (HKFP)-ийг ажиллуулахыг хүссэн боловч Хонконгийн цагаачлалын алба түүнд ажлын виз олгохоос шалтгаангүйгээр татгалзав.

## Есдүгээр сар

### 22-ны өдөр

Хонконгийн засгийн газар цаашид хэвлэлийн бага хурлыг зөвхөн "олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн" хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд зориулан хийх бөгөөд үүний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй гэдгээ мэдэгдсэн нь үнэн хэрэгтээ хараат бус хэвлэл мэдээлэл, чөлөөт сэтгүүлчдийг үгүйсгэсэн хэрэг юм.

### 23-ны өдөр

Гадаадын сурвалжлагчдын клубийн зүгээс хэвлэл мэдээллийн талаар баримтлах цагдаагийн шинэ удирдамж гарсанд санаа зовниж буйгаа илэрхийлсний дараа Хятадын Гадаад хэргийн яам тус клубийг "үймээн самуун дэгдээсэн" хэмээн буруутгаж, нутаг дэвсгэрийн хэрэгт "хөндлөнгөөс оролцохоо зогсоох"-ыг шаардав.

### 27-ны өдөр

Хонконгийн олон нийтийн өргөн нэвтрүүлгийн RTHK байгууллага нь сэтгүүлч **Набела Косэрийг** Хонконгийн төрийн өндөр албан тушаалтнуудад хатуу шулуун асуулт тавьсаны улмаас түүнд холбогдох хэргийг дахин сөхөж, гурван жилийн туршилтын хугацааг нь нэмж 120 хоногоор сунгав.

## Аравдугаар сар

### 15-ны өдөр

Үндэсний аюулгүй байдлын газрын цагдаагийн алба хаагчид Apple Daily сониныг үндэслэгч **Жимми Лайн** Кувлон дахь хувийн ажлын байр руу дайран оров.

### 19-ний өдөр

2020 оны арваннэгдүгээр сард болсон эсэргүүцлийн жагсаалыг сурвалжлах үеэр цагдаагийн ажилтан индонезийн сэтгүүлч **Веби Мега Индахийг** нүд рүү нь буудсаны улмаас нэг нүд нь хараагүй болсон хэргийн дараа Хонконгийн дүүргийн зөвлөлийн гишүүнд шийтгэл ногдуулав.

## Арваннэгдүгээр сар

### 3-ны өдөр

Чөлөөт продюсер **Чой Юук-лин** (Бао Чой гэдгээр мөн танигдсан) RTHK-ийн баримтат нэвтрүүлэгт зориулан судалгаа хийх явцдаа Юэн Лон дүүргийн метроны буудалд бүлэг этгээд зорчигчид руу дайрахад цагдаа нарын зүгээс ямар ч арга хэмжээ аваагүй талаар онцлон дурдсанд түүнийг "худал мэдээлэл өгсөн" хэргээр цагдаа нар баривчлав. Мөн өдөр түүнийг батлан даалтад гаргасан бөгөөд 2021 оны нэгдүгээр сард болсон шүүх хурлаар гэм буруугүйд тооцсон.

## Арванхоёрдугаар сар

### 1-ний өдөр

Өргөн нэвтрүүлгийн байгууллага Ковид-19-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөллөөр шалтаглан нутаг дэвсгэртээ хамгийн нэр хүндтэй эрэн сурвалжлах нэвтрүүлгийн нэг болох News Lancet-ийн багийн бүх гишүүдийг оролцуулан 40 хамтран зүтгэгчийг нь ажлаас халсаныг эсэргүүцэн i-Cable мэдээний сувгийн сэтгүүлчид олноор ажлаасаа гарцаав.

### 2-ны өдөр

**Жимми Лай** болон Next Digital компанийн хоёр захирлыг залилангийн хэрэгт буруутгав. Хоёр хамтран зүтгэгчдэд нь нэгэн зэрэг шийтгэл ногдуулснаас ялгаатай нь Лайг батлан даалтад гаргахаас татгалзжээ.

### 11-ний өдөр

**Жимми Лайг** Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан" хэргээр шийтгэсэн. Түүнийг хожим нь гэрийн хорионд байх хатуу нөхцөлтэйгээр батлан даалтад гаргав.

### 31-ний өдөр

Бээжин болон Хонконгийн засгийн газрын албан тушаалтнуудын шахалтаар прокурорууд **Жимми Лайг** батлан даалтад гаргах шийдвэрийг хүчингүй болгож, Хонконгийн Давж заалдах шатны шүүхээс түүнийг дахин шоронд хорих шийдвэр гаргав.



## Нэгдүгээр сар

### 6-ны өдөр

Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагчид, сэтгүүлч асан **Клаудиа Мо**, **Гвинет Хо** нар ардчиллыг дэмжигч хөдөлгөөний бусад 53 хүний хамт Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулах зорилгоор хуйвалдсан" хэрэгт сэжиглэгдэн баривчлагдаж, удалгүй батлан даалтад гарсан. Тухайн өдөр цагдаагийн ажилтнууд ардчиллыг дэмжигч Apple Daily, InMedia, Stand News зэрэг мэдээллийн хэрэгслүүдийн редакцад нэгжлэг хийж, 7 дугаар сард Хонконгд болсон ардчиллын төлөөх анхан шатны сонгуульд өрсөлдсөн нэр дэвшигчидтэй холбоотой баримт бичиг гаргаж өгөхийг тэднээс шаардсан.

### АНХААРЛЫН ТӨВД



## Клаудиа Мо

© Peter Parks / AFP

Хонконгийн хууль тогтоох зөвлөлийн гишүүн асан, сэтгүүлч асан Клаудиа Мо нь тус нутаг дэвсгэр дэх хэвлэлийн эрх чөлөөний тууштай хамгаалагч байсан бөгөөд 2021 оны нэгдүгээр сард Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан" хэргээр ардчиллын төлөөх хөдөлгөөний бусад 53 хүний хамт баривчлагдав.

Мо нь 2012-2020 онд хууль тогтоогчоор ажиллаж байсан ба 1986-1991 онд Agence France-Presse (AFP) агентлагийн сурвалжлагч, хожим нь 2005 он хүртэл Хонконгийн радио, телевизийн (RTHK) хөтлөгч, Apple Daily, Ming Pao сонины тоймчоор ажиллаж байсан. Тэрбээр 2019 онд RSF-тэй хамтран Хууль тогтоох зөвлөлийн байранд Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс танилцуулах хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж байв.

Клаудиа Мо 2021 оны 2 дугаар сарын 28-наас хойш цагдан хоригдож буй. Түүнийг 4 дүгээр сард батлан даалтад гаргахаас хоёр дахь удаагаа татгалзсан явдал түүний урьд өмнө "гадаадын хэвлэл мэдээлэлд ярилцлага" өгсөнтэй ямар нэгэн байдлаар холбоотой.

## Хоёрдугаар сар

### 7-ны өдөр

Интернэт радиогийн сувгийн D100 хөтөлбөрийн хөтөлгөч **Ван Иу-Син** ("Giggs" нэрээр мөн танигдсан) Хонконг болон Хятадын эрх баригчдыг шүүмжилсний төлөө Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "үймээн самуун өдөөхийг завдсан" хэргээр ял шийтгүүлэв. Өмнө нь түүнийг эхнэрийн хамт 2020 оны 11 дүгээр сарын 21-нд "салан тусгаарлах үйл ажиллагаа явуулсан" ба мөнгө угаасан хэрэгт сэжиглэн, саатуулан баривчилж байсан.

### 11-ний өдөр

Бээжингийн зүгээс Шинжаан дахь Уйгур үндэстний цөөнхтэй хэрхэн харьцаж буй талаар мэдээлснээс үүдэлтэй Хятадын өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллага хориг тавьсаны дараа RTHK олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага BBC World News сувгийг зогсоов.

### 28-ны өдөр

Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагчид, сэтгүүлч асан **Клаудиа Мо**, **Гвинет Хо** нарыг Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан" хэрэгт буруутгаж, улмаар батлан даалтад гаргахаас татгалзав.

## Гуравдугаар сар

### 1-ний өдөр

Хонконгийн засгийн газар RTHK олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг шинэчилж, удирдлагыг нь сольсон бөгөөд шинээр томилогдсон Патрик Ли тус байгууллагад цагдан хяналтыг тогтоов.

## АНХААРЛЫН ТӨВД



© Candice Chau / Hong Kong Free Press. Сэтгүүлч Набела Косерт түр гэрээгээр ажиллах эсвэл ажлаасаа чөлөөлөгдөх шаардлага тавьсаны дараа Хонконгийн радио, телевизийн ажилтнуудын холбоо түүнийг дэмжиж жагсав.

### Хонконгийн радио, телевиз (RTHK)-ийн албаны захирал

2021 оны гуравдугаар сарын 1-нээс Патрик Ли Хонконгийн радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн албаны захирлаар ажиллаж эхэлснээс хойш хамгийн багадаа 12 шинэ уран бүтээлийг богино хугацаанд эфирээс хасаж, мөн "Хонконгтой холбогдох нь" баримтат нэвтрүүлэг, "Хэмнэл" мэдээний ток шоу нэвтрүүлгийн 200 гаруй дугаарыг тус байгууллагын Youtube суваг дээрээс устгав. Хэвлэл мэдээллийн чиглэлээр ямар ч туршлагагүй хүнд сурталт Патрик Ли түүний нийтэд түгээхэд тохиромжгүй гэж үзсэн контентийг бүтээхэд оролцсон ажилтнуудын цалинг хоёр дахин бууруулна хэмээн сүрдүүлэв.

Патрик Ли албан тушаалд томилогдсоноор гүйцэтгэх продюсер **Фон Хю-шан**, **Лю Вай-лин**, **Дорис Вон**, шагналт сурвалжлагч **Ивонне Тон** нарын дор хаяж дөрвөн ажилтан ажлаасаа чөлөөлөгдсөн. Мөн засгийн газрын албан тушаалтнуудад хатуу шулуун асуулт тавьдагаараа нэрд гарсан сэтгүүлч **Набела Косерын** гэрээг сунгахаас татгалзав.



## Дөрөвдүгээр сар

### 7-ны өдөр

RTNK-ийн удирдлагууд тэдний зөвшөөрөл өгөхөөс татгалзсаны улмаас эфирээс хассан материал бэлтгэсэн сэтгүүлчдийн цалинг хоёр дахин бууруулна хэмээн сүрдүүлэв.

### 12-ны өдөр

АНУ-д төвтэй өдөр тутмын The Epoch Times сонины Хонконг дахь хэвлэх цех руу нүүрээ халхалж, зэвсэглэсэн дөрвөн этгээд дайран орж, ажилтнуудыг айлган сүрдүүлж, гол хэвлэх машин, бусад тоног төхөөрөмжийг лантуугаар цохиж эвдлэв.

### 16-ны өдөр

Apple Daily сонины үүсгэн байгуулагч **Жимми Лайд** "зөвшөөрөлгүй цуглаан зохион байгуулсан" хэргээр 14 сарын хорих ял ногдуулсан төдийгүй Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан" гэдэг үндэслэлээр буруутгав.

### 22-ны өдөр

Эрэн сурвалжлах сэтгүүлч **Чой Юук-лин** Хонконгийн радио, телевизийн баримтат нэвтрүүлэгт ардчиллын төлөөх жагсаал цуглааны үеэр жагсагчдыг болон энгийн ард иргэдийг хамгаалах талаар цагдаа нарын зүгээс ямар нэг арга хэмжээ аваагүй талаар шүүмжилсний төлөө түүнийг "худал мэдээлэл өгсөн" хэргээр шийтгэл ногдуулав.

### 28-ны өдөр

Хонконгийн захирагч Кэрри Лам олон нийтийн RTNK телевизээр өдөр бүр дөрвөн удаа цацагддаг кантон хэл дээрх ток шоугаа хөтөлж эхэлсэн нь түүнд сэтгүүлчдийн асуултаас бултах, Хятадын зүгээс хэрэгжүүлж буй сонгуулийн шинэчлэлийг таниулан сурталчлах боломж олгосон.

## Тавдугаар сар

### 3-ны өдөр

Хонконгийн радио, телевиз засгийн газрын албан тушаалтнуудад хатуу шулуун асуулт тавьдагаараа алдартай сэтгүүлч **Набела Косертой** байгуулсан гэрээгээ цуцлав.

### 10-ны өдөр

Радиогийн хөтөлгөч **Ван Иу-Син** ("Giggs" нэрээр мөн танигдсан) мөнгө угаасан хэргийн таван зүйл ангиас гадна "үймээн самуун дэгдээхийг санаархсан үйлдэл" хийхээр хуйвалдаан зохион байгуулсан хэргээр нэмэлт ял сонсов.

### 11-ний өдөр

Epoch Times сонины сурвалжлагч **Сара Лиан** байрныхаа ойролцоо үл таних этгээдэд бейсболын цохиураар нүдүүлсний улмаас эмнэлэгт хүргэгдэв.

### 14-ний өдөр

Хонконгийн эрх бүхий албан тушаалтнууд Apple Daily сониныг үүсгэн байгуулагч **Жимми Лайн** Next Digital Limited дахь хувьцаа, түүний эзэмшдэг бусад гурван компанийн данс зэрэг хөрөнгийг Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу битүүмжлэн царцаав.

### 28-ны өдөр

**Жимми Лай** 2019 оны аравдугаар сард "зөвшөөрөлгүй" эсэргүүцлийн жагсаал "зохион байгуулсан" хэргээр Хонконгийн шүүхээс дахин 14 сарын хорих ял сонсов. Энэ ялыг өмнө нь ижил төрлийн хэргээр тулгасан өөр хоёр ял дээр нэмж оногдуулсан бөгөөд ингэснээр Лай нийтдээ 20 хүртэл сарын хорих ял эдлэхээр болов.

## Зургадугаар сар

### 17-ны өдөр

Ойролцоогоор 500 цагдаагийн алба хаагч Хонконгийн хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл Apple Daily сонины байранд дайран орсоны зэрэгцээ эрх бүхий албан тушаалтнууд тус сонины 18 сая хонконг доллар (2 сая орчим евро)-ын хөрөнгийг битүүмжлэн царцаав. Apple Daily сонины ерөнхий редактор **Райан Лау**, гүйцэтгэх захирал **Чеюн Ким-хун**, үйл ажиллагаа эрхэлсэн захирал **Ройстон Чоу**, туслах нийтлэлч **Чан Пуй-ман** болон Apple Daily Digital ХМХ-ийн захирал **Чэун Чи-вай** нарыг Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан" хэрэгт сэжиглэн, баривчлан саатуулав.

### 23-ны өдөр

Цагдаа нар байранд нь дайран орж, гол ажилтнуудыг нь саатуулан баривчилж, засгийн газраас Apple Daily сонин, түүний толгой Next Digital компанийн хөрөнгийг царцаасны дараа 6 дугаар сарын 24-нд Apple Daily сонин хаагдсан тухайгаа зарлав. Цагдаа нар тус сонины редакцын зохиолч, тоймч, Хятадын дэглэмийг шүүмжилдэгээрээ нэрд гарсан "Ли Пин" нууц нэрээр танигдсан **Юун Чин-Киг** саатуулан баривчлав.

### 27-ны өдөр

Apple Daily сонины ахмад сэтгүүлч, англи хэл дээрх булангийн гүйцэтгэх ерөнхий редактор "Ло Фу" нэрээр танигдсан **Фун Вай-коныг** Их Британи руу нисэх гэж байхад нь онгоцны буудал дээрээс саатуулан баривчлав.



© Anthony Wallace / AFP. Хонконгийн цагдаа нар өмнөх өдөр нь Apple Daily сонины гол ажилтнуудыг саатуулан баривчилсны дараа сонины мухлагийн ажилчид 2021 оны 6 дугаар сарын 18-нд тус сонины дугааруудыг ангилан ялгав.

1995 онд үүсгэн байгуулагдсан Apple Daily сонин нь Бээжингийн дэглэмийн суртал ухуулгыг сөрсөн мэдээ нийтэлж, түүний дарангуйлагч бодлогыг шүүмжилсэн өгүүлэл, нийтлэл бичиж зориглосон хятад хэл дээрх сүүлийн томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэг байсан бөгөөд олон жилийн турш засгийн газар болоод Бээжинг дэмжигч этгээдүүдийн дарамт шахалтад өртөж байсан юм.

2021 оны 6 дугаар сарын 17-нд 500 орчим цагдаагийн ажилтан Apple Daily сонины төв байранд дайран орж, гүйцэтгэх удирдлагын таван гишүүнийг “гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдах явуулга хийсэн” хэрэгт сэжиглэн, саатуулсан баривчилсан. 2020 оны 6 дугаар сард Хятадын эрх баригчдын баталсан Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу дээрх хэрэгт бүх насаар хорих ял оноодог. Засгийн газрын шийдвэрээр Apple Daily сонины хөрөнгийг битүүмжлэн царцааснаас улбаалан тус хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнууд, ханган нийлүүлэгчдэдээ төлбөр төлөх нөхцөлгүй болсны тул үйл ажиллагаагаа зогсоож буйгаа Next Digital media группийн захирлуудын зөвлөл 6 дугаар сарын 23-нд мэдэгдэв. Тус сонин 6 дугаар сарын 24-нд хаагдав.

Apple Daily сонины ерөнхий менежер **Чеюн Ким-хун**, гүйцэтгэх ерөнхий редактор **Лам Ман-чун**, туслах нийтлэлч **Чан Пуй-ман**, ерөнхий редактор **Райан Лау**, редакцийн зохиолч **Фун Вай-кон**, **Юун Чин-Ки** (Ло Фун болон Ли Пин нууц нэрээр тус тус танигдсан) нарын зургаан ажилтан өнөөг хүртэл цагдан хоригдсон хэвээр байна.



© Anthony Wallace / AFP. 2021 оны 6 дугаар сарын 17-нд цагдаа нар ерөнхий редакторын туслах Чан Пуй-маныг Apple Daily сонины байрнаас саатуулан баривчлав.

## Долдугаар сар

### 15-ны өдөр

Хонконгийн сэтгүүлчдийн холбоо жилийн тайландаа засгийн газрын "сэмлэн урсан" хэвлэлийн эрх чөлөө эрс доройтсоныг зэмлэн буруушаав.

### 21-ний өдөр

Apple Daily сонины арав дахь ажилтан асан, гүйцэтгэх ерөнхий редактор **Лам Ман-чун** гэрээсээ цагдаа нарт баривчлагдаж, Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан" хэргээр ял шийтгүүлэв.

## Наймдугаар сар

### 3-ны өдөр

Хонконгийн Initium Media цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл төв байраа Сингапур руу нүүлгэх болсноо зарлаж, Үндэсний аюулгүй байдлын хууль хэрэгжиж эхэлснээс хойш гадаад руу нүүн шилжсэн Хонконгийн анхны мэдээллийн хэрэгсэл болов.

### 9-ний өдөр

Хонконгийн захирагч Кэрри Лам RTHK олон нийтийн радио, телевиз нь тус нутаг дэвсгэрт "эх оронч үзлийг гүн төлөвшүүлэх" үүднээс төрийн мэдлийн Хятадын медиа групп (CMG)-тай хамтран ажиллах тухайгаа мэдэгдэв.

## Есдүгээр сар

### 29-ний өдөр

RTHK өргөн нэвтрүүлгийн байгууллага сэтгүүлчдийг "үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхлыг хамгаалахад засгийн газарт дэмжлэг үзүүлэх", Хонконгийн гүйцэтгэх засаглал болон Хятадын засгийн газрыг "үзэн ядах, ялгаварлан гадуурхах, дайсагналцуулах"-д өдөөн турхирахаас буюу уг үйлдлийг гүнзгийрүүлэхээс зайлсхийх, "гадаадын засгийн газар буюу улс төрийн байгууллага"-тай харилцахаас татгалзах тухай редакцийн шинэ удирдамж батлан гаргав.

## Аравдугаар сар

### 1-ний өдөр

Олон жилийн туршлагатай Хонконгийн Stand News болон Citizen News цахим сонины сэтгүүлчдийг Хятадын үндэсний баярын арга хэмжээнд оролцохыг хязгаарлав.

### 19-ний өдөр

2019 оны ардчиллыг дэмжих жагсаалын үеэр сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдсэн цагдаагийн хүчирхийлэлтэй холбоотой 27 гомдол ирснээс Хонконгийн цагдаагийн газар нэгээс бусдыг нь хүлээн авахаас татгалзсан гэж Хонконгийн сэтгүүлчдийн холбоо мэдэгдэв.

## Арваннэгдүгээр сар

### 4-ний өдөр

Шагналын эзэн DB Channel цахим мэдээллийн хэрэгсэл шалтгаанаа тайлбарлахгүйгээр үйл ажиллагаагаа зогсоов. Түүний үүсгэн байгуулагч Фрэнки Фун 2021 оны хоёрдугаар сараас хойш Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу "хорлон сүйтгэх зорилгоор үгсэн хуйвалдсан" хэргээр хоригдож байгаа бол нөгөө үүсгэн байгуулагч Ву Гин 2021 оны тавдугаар сард хувийн шалтгаанаар Тайвань руу шилжин суурьшсан гэдгээ мэдэгдэв.

### 5-ны өдөр

Гадаадын сурвалжлагчдын клубээс хийсэн судалгааны үр дүнгээс харахад Үндэсний аюулгүй байдлын хууль хэрэгжиж эхэлснээс хойш сэтгүүлчдийн ажиллах орчин нөхцөл дордсон гэж гадаадын сурвалжлагчдын 84 хувь нь үзсэн бол 50 шахам хувь нь хэвлэлийн эрх чөлөөний доройтлоос үүдэн тус хотыг орхин гарахаар төлөвлөж буйгаа илэрхийлжээ.

### 12-ны өдөр

Хонконгийн цагаачлалын албаныхан The Economist сэтгүүлийн сурвалжлагч **Сью-Лин Воны** ажлын визийг сунгахаас ямар нэгэн тайлбаргүйгээр татгалзав.

### 25-ны өдөр

Хонконгийн харилцаа холбооны зохицуулах байгууллагаас "Хөтлөгч" хошин нэвтрүүлэг бодит үнэнийг гуйвуулсан, цагдаагийн хүчнийг гутаан доромжилсон агуулга түгээсэн гэж үзэн, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн RTHK байгууллагын эсрэг гаргасан шийдвэрийг Хонконгийн шүүхээс хэсэгчлэн хангав.

## Арванхоёрдугаар сар

### 13-ны өдөр

Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагч **Жимми Лай, Гвинет Хо** нар 2020 онд Хонконгд болсон хориотой жагсаал цуглаанд оролцсон хэргээр 13 ба 6 сарын хорих ялаар тус тус шийтгүүлэв.

### 28-ны өдөр

Хонконгийн прокурорууд Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу **Жимми Лай** болон Apple Daily сонины газар ажиллаж байсан зургаан хүний эсрэг "үймээн самуунд турхирсан нийтлэл түгээсэн" хэргээр нэмэлт ял тулгав.

### 29-ний өдөр

Цагдаагийнхан Stand News хараат бус цахим мэдээллийн хэрэгслийн байранд дайран орж, багийн одоогийн болон хуучин зургаан гишүүнийг баривчилсны дараа үйл ажиллагаагаа зогсоох болсноо зарлав. Мөн өдөр Хонконгийн сэтгүүлчдийн холбооны тэргүүн, Stand News сонины орлогч редактор **Ронсон Чаныг** авч яваад, байцаасны дараа суллав.



## АНХААРЛЫН ТӨВД



© Tyrone Siu / REUTERS. Stand News сонины ер нхий редактор Патрик Лам цагдаа нарт баривчлагдав.

Stand News нь Хонконгд байрладаг, хятад хэл дээрх ашгийн бус мэдээллийн сайт байсан бөгөөд 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хонконгийн нийгэм, эдийн засгийн асуудлаар чамбай өгүүлэл, нийтлэл гаргадагаараа нэрд гарсан тус сайт Үндэсний аюулгүй байдлын хуульд холбогдох бүхий л шүүн таслах ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээ сурвалжилга бэлтгэн хүргэж байв. Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) байгууллагын 2021 оны Хэвлэлийн эрх чөлөөний шагналд нэр дэвшиж байсан.

Next Digital групп болон түүний урдаа барьдаг Apple Daily сонин татан буугдсанаас хойш яг зургаан сарын дараа буюу 12 дугаар сарын 29-ний өглөө Stand News сонины байранд 200 цагдаа дайран орохын зэрэгцээ Үндэсний аюулгүй байдлын газрын цагдаагийн алба хаагчид багийн одоогийн болон хуучин зургаан гишүүнийг дээд тал нь хоёр жилийн хорих ялтай “үймээн самуунд турхирсан нийтлэл бичихээр үгсэн хуйвалдсан” хэргээр саатуулан баривчилсан. Ерөнхий редактор **Патрик Лам**, **Чун Пуи-куен** нарыг батлан даалтад гаргахаас татгалзсан тул шүүх хурал хүртэл үргэлжлүүлэн хорих юм. Мөн өдрийн орой Stand News сонины зүгээс олон нийтийн сүлжээгээр дамжуулан компанийн хөрөнгийг засгийн газраас битүүмжилсэн тул хэвлэн нийтлэхээ зогсоож, ажилтнуудаа чөлөөлөхөө мэдэгдэв.

# 2022

## Нэгдүгээр сар

### 3-ны өдөр

2017 онд үүсгэн байгуулагдсан хятад хэл дээрх ашгийн бус, хараат бус Citizen News цахим мэдээллийн хэрэгсэл "нийгэмд эрс өөрчлөлт өрнөж, хэвлэл мэдээллийн орчин улам доройтож буй" талаар дурдаад, "ажилтнуудаа хамгаалах" шаардлагын улмаас хаагдсанаа мэдэгдэв.

### 4-ний өдөр

Mad Dog Daily цахим мэдээллийн хэрэгсэл хууль эрх зүйн эрсдэлээс сэргийлэх, ажилтнуудаа хамгаалах шаардлагатай гэдэг үндэслэлээр үйл ажиллагаагаа зогсоов.

### 12-ны өдөр

Эх орноосоо урвах, салан тусгаарлах, үймээн самуун дэгдээх, хорлон сүйтгэх гэмт хэргүүдийг шийдвэрлэхийн тулд Хонконг үндэсний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр илүү олон хууль тогтоомж батлах болно хэмээн Кэрри Лам захирагч мэдэгдэв.

### 21-ний өдөр

Хонконгийн Үйлдвэрчний эвлэлийн бүртгэлийн газар (RTU) Хонконгийн сэтгүүлчдийн холбооноос зохион байгуулсан тодорхой үйл ажиллагаа нь тэдний зорилгод нийцэж буй эсэхэд хариулт нэхэж, мөн олон нийтийн сүлжээн дэх зарим нийтлэлийнхээ талаар тайлбар өгөхийг шаардав. Тус холбоог өмнө нь Аюулгүй байдлын нарийн бичгийн дарга Крис Тан их сургуулиудын хотхонд "нэвтэрч", сэтгүүл зүйн оюутнуудыг "уургалан" гишүүнээр элсүүлсэн хэмээн шүүмжилж байсан юм.

## Хоёрдугаар сар

### 7-ны өдөр

Нийт 23 орноос бүрдсэн Хэвлэлийн эрх чөлөөний эвсэл Хонконг болон эх газрын Хятадын эрх баригчид хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, Хонконг дахь орон нутгийн хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг дарангуйлж байгаад "гүнээ санаа зовниж" буйгаа илэрхийлэв.

### 14-ний өдөр

Хоригдож буй Хонконгийн сэтгүүлчдийг суллахыг уриалж, хэвлэлийн эрх чөлөөний аян өрнүүлсэн Их Британид төвтэй "Хонконгийг ажиглагч" (Hong Kong Watch) төрийн бус байгууллагын цахим хуудсыг Хонконг дахь интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хэд хэдэн компани хаав.

## Гуравдугаар сар

### 1-ний өдөр

Local Press хятад хэл дээрх ашгийн бус, хараат бус цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл учир шалтгаанаа тайлбарлахгүйгээр үйл ажиллагаагаа зогсоов.

### 14-ний өдөр

Хоригдож буй Хонконгийн сэтгүүлчдийг суллахыг уриалсан "Хонконгийг ажиглагч" байгууллагыг "Үндэсний аюулгүй байдлын хууль зөрчсөн" байж болзошгүй хэмээн үзэж, цахим хуудсаа устгахыг Хонконгийн цагдаагийн газрын Үндэсний аюулгүй байдлын хэлтсээс албан ёсоор шаардав.

## Дөрөвдүгээр сар

### 11-ний өдөр

Өдгөө үйл ажиллагаа нь зогссон хараат бус Stand News хэвлэл мэдээллийн хэрэгслийн ахмад сэтгүүлч, тоймч **Аллан Ауг** Үндэсний аюулгүй байдлын газрын цагдаа нар "үймээн самуунд турхирсан нийтлэл бичихээр үгсэн хуйвалдсан" хэргээр Хонконг дахь гэрээс нь баривчилж, хожим нь батлан даалтад гаргасан.

### 20-ны өдөр

Apple Daily, Stand News сонин ахлах ажилтнуудыг оролцуулан 13 сэтгүүлч, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалагчид тус нутаг дэвсгэр дэх Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас дараа сард хийхээр дахин хойшлогдсон шүүх хурлаа хүлээн, өдийг хүртэл цагдан хоригдож байна.

# RSF-ИЙН ТАЙЛАН ИЛТГЭЛ

## Хятад дахь сэтгүүл зүйн огцом ухралт

2022 оны 12 дугаар сард нийтлэгдсэн “Хятад дахь сэтгүүл зүйн огцом ухралт” нэртэй 82 хуудас бүхий сэтгэл эмзэглүүлсэн тайлан илтгэл нь Хятад улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх олон улсын үүрэг амлалтаа эрчтэй зөрчиж буй үйлдлийг харуулна. Эрэн сурвалжлах тус тайлан илтгэл Хятад дахь сэтгүүлчид, гадаадын сурвалжлагчдын эсрэг эрх баригчдын дарангуйллын арга хэрэгслийг нягтлан шинжилж, нэгэн цагт хэвлэлийн эрх чөлөөний үлгэр жишээ гэгдэж байсан Хонконг дахь хэвлэлийн эрх чөлөөний доройтолд дүн шинжилгээ хийсэн юм. Түүнчлэн хилийн чанад дахь мэдээллийн хүртээмжид хяналт тавих Бээжингийн стратегийн талаар дэлгэрэнгүй өгүүлэхийн зэрэгцээ Хятадын эрх бүхий албан тушаалтнууд, гадаадын засгийн газрууд, олон улсын байгууллагууд, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалга, зөвлөмж хүргүүлэв.



© Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF)

Тус тайлан илтгэлийг RSF-ийн цахим хуудаснаас араб, англи, франц, герман, япон, солонгос, монгол, португал, орос, испани, хятад (хялбаршуулсан ба уламжлалт) зэрэг 12 хэл дээр татаж авахаас гадна дараах холбоосоор үзэх боломжтой: <https://bit.ly/3La93cv>



# **RSF** Хил Хязгааргүй Сурвалжлагчид

ХИЛ ХЯЗГААРГҮЙ СУРВАЛЖЛАГЧИД (RSF) нь дэлхий дахинд сэтгүүл зүйн эрх чөлөө, олон ургальч болоод хараат бус байдлыг дэмжин хамгаалдаг олон улсын байгууллага юм. Парис хотноо төвтэй тус байгууллага нь НҮБ болон ЮНЕСКО-д зөвлөх эрхтэй бөгөөд олон улсын арван дөрвөн товчоотой, дэлхийн 130 оронд сурвалжлагчтай юм.

ХАВТАСНЫ ЗУРАГ: © VERNON YUEN / AFP. Apple Daily сониныг үндэслэгч Жимми Лайг “гадаадын хүчнүүдтэй үгсэн хуйвалдсан” хэрэгт сэжиглэн, баривчлан хорив.

**ОЛОН УЛСЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗАР**

**- CS 90247 - 75083 PARIS**

**CEDEX 02 УТАС.+33144838484**

**WWW.RSF.ORG**